

ГАРЧИГ

ОРШИЛ	2
1. Төслийн товч танилцуулга.....	3
2. 2023 оны уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл	9
3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөөний биелэлт.....	14
4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	24
5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	29
6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	32
7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	32
8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	33
9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	36
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт.....	41
11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	43
12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт.....	45

ДҮГНЭЛТ

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ:

ОРШИЛ

ГБНБ ХХК нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Баруун захцагийн ордод 2011 оноос эхлэн өнөөг хүртэл алт олборлох үйл ажиллагаа явуулж байна.

“Баруун захцаг”-ийн (MV-008998) ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь байр L-47-137 хавтгайд Загцаг уулын зүүн урд бэлд 252 га талбайг эзлэн оршдог. Баруун захцагийн алтны шороон орд нь Эрдэнэт хотоос баруун урагш 170км-т, Улаанбаатар хотоос баруун хойш 260 км-т, Дархан хотоос баруун тийш 240 км-т Бүрэгхангай сумын төвөөс зүүн зүгт 45 км-т байрладаг

Тус компани Монгол Улсын холбогдох хуулийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ)-г төслийн бүхий л үе шатанд мэргэжлийн байгууллагаар дэс дараатай хийлгэж, түүний зөвлөмж, заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг тодорхойлж, бодитоор үнэлж, бохирдлыг бууруулж, арилгах арга хэмжээг авч ажиллаж байна.
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм, журмыг сахин биелүүлэн ажиллаж байна.
- Ашигт малтмалын хайгуул хийх, уурхайн олборлолт ба уурхайн хаалт зэрэг үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчны асуудлыг жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд туслах зорилгоор ажилчдад байгаль орчныг хамгаалах сургалт зохион байгуулан ажиллаж байна
- Уурхайн үйл ажиллагааны явцад нөхөн сэргээлтийг гүйцэтгэж байна.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хянах, хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагааг тогтмол сайжруулан ажиллахад анхаарч байна.

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших MV-008998 тоот тусгай зөвшөөрөлийн дугаартай “Баруун Захцаг”-ийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл.

1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн нэр, хаяг

“ГБНБ” ХХКомпани, Улсын бүртгэлийн дугаар-9011025150, регистрийн дугаар-2615797, Хаяг: Баянгол дүүрэг 20-р хороо, Гацуурт ХХК-ний байр 3 давхарт 312 тоот.

1.3 Төслийн зорилго

Улс орны нийгэм, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх, шинээр ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулах, байгаль орчинд сөрөг нөлөө байгатай техник технологи ашиглан олборлолт явуулж, байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлах, таслан зогсоох арга хэмжээг шийдвэрлэх асуудлыг компаниас бодлогын хэмжээнд дэмжиж, энэ талаар доривтой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.


1.4 Төслийн байршил

“ГБНБ” ХХК нь 2004 байгуулагдсан бөгөөд Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дахь Баруун Захцагийн алтны шороон ордод 252.02 га талбай бүхий MV-008998 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

Талбайн булангийн цэгүүдийн солбицол

Хүснэгт-1

Дугаар	Уртраг	Өргөрөг
1	104 ⁰ 21 ¹ 30.93”	48 ⁰ 16 ¹ 6.82”
2	104 ⁰ 21 ¹ 30.93”	48 ⁰ 15 ¹ 51.82”
3	104 ⁰ 21 ¹ 55.1”	48 ⁰ 15 ¹ 51.82”
4	104 ⁰ 21 ¹ 55.2”	48 ⁰ 15 ¹ 40.33”
5	104 ⁰ 21 ¹ 40.92”	48 ⁰ 15 ¹ 36.81”
6	104 ⁰ 21 ¹ 21.03”	48 ⁰ 15 ¹ 20.89”
7	104 ⁰ 21 ¹ 13.41”	48 ⁰ 15 ¹ 20.85”
8	104 ⁰ 21 ¹ 13.43”	48 ⁰ 15 ¹ 19.31”
9	104 ⁰ 21 ¹ 10.93”	48 ⁰ 15 ¹ 21.82”
10	104 ⁰ 20 ¹ 58.43”	48 ⁰ 15 ¹ 20.14”
11	104 ⁰ 20 ¹ 47.94”	48 ⁰ 15 ¹ 14.48”
12	104 ⁰ 20 ¹ 40.93”	48 ⁰ 15 ¹ 16.82”
13	104 ⁰ 19 ¹ 30.93”	48 ⁰ 15 ¹ 16.82”
14	104 ⁰ 19 ¹ 30.93”	48 ⁰ 15 ¹ 41.81”
15	104 ⁰ 21 ¹ 0.94”	48 ⁰ 15 ¹ 41.81”
16	104 ⁰ 21 ¹ 0.94”	48 ⁰ 16 ¹ 6.82”



Зураг. 1. Байрилын тойм зураг

Тус орд нь Улаанбаатар хотоос баруун хойш 240 км-т, Бүрэгхангай сумын төвөөс зүүн зүгт 45 км-т Туул голын баруун эрэгт оршино.



Зураг: 2. MV-008998 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн сансраас харагдах байдал

1.5 Үйл ажиллагааны хүрээ

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах аливаа төсөл нь байгаль орчны хуулиудаар тогтоосон хэм хэмжээ ба төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсан стандарт, нормын шаардлагад нийцүүлэн хэрэгжих ёстой. “ГБНБ” ХХК-ийн “Баруун загцагийн алтны шороон орд”-ыг ил аргаар ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажилласан хуулийн зүйл, заалтууд, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандартуудын холбогдох шаардлагууд.

Монгол улсын хууль:

- ✓ Монгол Улсын үндсэн хууль (1992)
- ✓ Ашигт малтмалын тухай хууль (2006)
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012 он)
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай (1995), 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан
- ✓ Хог хаягдлын тухай (1994), 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан
- ✓ Газрын хэвлийн тухай (1989) -1995 хуульд нэмэлт өөрчлөлт орсон
- ✓ Газрын тухай (2002), 2003 онд 3 удаа, 2004 онд 1 удаа, 2005 онд 2 удаа, 2006, 2012 онд нэг удаа тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Байгалийн ургамлын тухай (1995), 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан
- ✓ Усны тухай хууль (2004), 2005, 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Газрын төлбөрийн тухай хууль (1997), 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан
- ✓ Агаарын тухай (1995), 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан
- ✓ Гамшгаас хамгаалах тухай хууль (2003 он) 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан
- ✓ Галын аюулгүй байдлын тухай хууль (1999 он) 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан

Сайдын тушаал, журам:

- ✓ Хог хаягдал булаах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, хог хаягдал булаах, устгах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тухай журам
- ✓ Хүн амын усны төлбөрийн хууль дүрэм, улсын байгаль орчны хорооны журам (1992)
- ✓ Хаягдал усыг зайлуулах журам, Байгаль орчин, Эрүүл мэндийн яамны хамтарсан журам, дугаар 169/171, 1995 он.
- ✓ Усны нөөцийг хамгаалах дүрэм, Байгаль орчин, Эрүүл мэндийн яамны хамтарсан журам, дугаар 143/А/352, 19 эрүүл ахуйн бүсийг хамгаалах горим, Байгаль орчны яам, Эрүүл мэндийн яам, Дэд бүтцийн яамны хамтарсан журам, дугаар 167/335/А/171.
- ✓ Усны чанарын норматив, усан хангамжийн тоног төхөөрөмжинд тавих шаардлагууд журам, дугаар 143/а/352, 1997 он.

Байгаль орчныг хамгаалах талаар мөрдөгдөж байгаа үндсэн стандартууд
Хүснэгт-2

№	Байгаль орчны стандартууд
1	MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага
2	MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага
3	MNS 5914:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага
4	MNS 5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
5	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
6	MNS (ISO) 4226:2000 Агаарын чанар. Ерөнхий ухагдахуун. Хэмжих нэгж
7	MNS 4585:2007 Агаарын чанар. Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
8	MNS (ISO) 4867:1999 Усны чанар – Дээжлэх – Хэсэг 3:Дээжийг боловсруулах ба хадгалах зөвлөмж
9	MNS 3342:1982 Байгаль орчны хамгаалал, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага
10	MNS 3597:1983 Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Гадаргын ба газрын доорхи усыг эрдэс бордооны бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага.
11	MNS (ISO) 5667-11:2000 Байгаль орчин. Усны чанар. Дээж авах. 5-р хэсэг: Ундны ус, хүнс болон ундаа үйлдвэрлэхэд хэрэглэгдэх уснаас дээж авах заавар
12	MNS 0899:1992 Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам ба эрүүл ахуйн шаардлага
13	MNS 0900:2005 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
14	MNS 4943:2011 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
15	MNS 4047:88 Байгаль орчныг хамгаалах. Усан мандал. Гадаргын усны чанарыг хянах журам
16	MNS 4288:95 Усны чанар. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих үндсэн шаардлага. Техникийн ерөнхий шаардлага
17	MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдаж болох бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтооно.
18	MNS 4943:2000 Ус болон хөрсөнд хаяж болох үйлдвэр ахуйн хаягдал бохир усны бохируудуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж бусад үзүүлэлтийн хязгаарыг тогтооно.
19	MNS 3297-91. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм
20	MNS 3342:1982 Гүний усыг хамгаалах ерөнхий шаардлага
21	MNS 3597:1983 Гүний усаар тэжээгдэж буй гадаргуугийн усыг хамгаалах тухай ерөнхий шаардлага

Уул уурхайн үйл ажиллагааны явцад эвдэрсэн газрыг ангилах, шимт хөрсийг хуулах, хадгалах, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийх техникийн ерөнхий шаардлага, эвдэрсэн газрыг ургамалжуулах стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

1.6 Ордын байгаль орчны төлөв байдал, Уул-техникийн нөхцөл

Ордын байгаль орчны төлөв байдал.

❖ Төсөл хэрэгжиж буй талбайд дунд зэрэг болон нам уулсын дов, гүвээрхэг, тэгш гэсэн 4 төрлийн гадаргуу ялгасан. Дунд зэргийн уулын гадаргуу нь захцаг уулын өмнөд хэсгийн салбар уулс юм. Энэ нутаг дэвсгэрт намхан уулсын гадаргуу зонхилдог ба энэ нь дунд уулсыг хүрээлсэн байдалтайгаар Захцаг уулсын салбар хэсэгт тархсан. Үнэмлэхүй өндөр нь 1200-1300 м байх ба харьцангуй өндөршилт нь 100-150 м байдаг.

❖ Хөрс газарзүйн мужлалаар Заамарын ойр орчимд хар хөрс зонхилж, татамын дагуу хагас уст хэлбэршлийн хөрс зонхилно. Хөрсний үржил шимт хэсэг нь 15-80 см хооронд хэлбэлздэг. Ландшафт –геохимийн мужлалаар тал хээрийн бүсд багтдаг тал хээрийн бор хүрэн хөрс зонхилно. Талбайд ой мод байхгүй, ойр хавьдаа ой модны нөөц багатай, хиаг, гуурст, ба шивээт хялгана, дэрс зэрэг хээрийн бүсийн залаат болон өвслөг ургамал голлон ургана.

❖ Хамгийн том гол нь орхон голыг баруун цутгал болох 600 км орчим урттай , 1-4 км өргөн хөндий бүхий Туул гол юм. Туул гол нь 16 –н зүйлийн агнуурын загастай бөгөөд эдгээрээс хилэм загас нь Монголын улаан номонд орсон нэн ховор загас юм. Мөн зэвэг загас нь ховор загасны тоонд ордог.

❖ Амьтаны аймгийн хувьд хээрийн хөхтөн амьтдаас хээрийн хэв шинжийн гол төлөөлөгч болох Мэргэчидээс урт сүүлт зурам, даагуур огдой, сарсан багваахай, бор туулай, шар үнэг, дорго цагаан үнэг зэрэг амьтад. Жигүүртэн аймгийн хувьд хөх дэглий, хээрийн галуу, ангир, бүх төрлийн нугас, шаазгай болжмор, хун зэрэг шувууд тусгай зөвшөөрөлтэй талбайн ойролцоо ажиглагддаг.

❖ Цаг агаарын хувьд их газрын эрс тэс уур амьсгалтай , жилийн дундаж хэм нь 23° байдаг. Хамгийн хүйтэн сар нь 1-р сар ба агаарын хэм нь -37° , хамгийн дулаан сар нь 7-сар ба агаарын хэм нь $+32^{\circ}$ хүрдэг. Жилийн дундаж хур тундасны хэмжээ 367,3 мм-ээс хэтэрдэггүй ба үүний 8% зуны улиралд бороо байдлаар ордог Өвөл 5-25 см цасан бүрхүүл тогтож улиралын хөлдөлтийн гүн 2.5 м хүрдэг ба голчлон баруун өмнөөс 5-10 м/сек хурдтай салхи салхилдаг тул уурхайн үйл ажиллгааг дулааны улиралд явуулдаг.

1.7 Ордын уул-техникийн нөхцөл

Орд нь Туул голын хөндийн дагуу зүүн хойноос баруун урагшаа сунан тогтсон, давхарга хэлбэрийн биет байна. Газрын гадаргуугийн өндөржилт 962-965м, харьцангуй өндөржилт 3 м байна. Орд нь дундажаар 10-15.0 метр зузаантай дөрөвдөгчийн хурдас болон хагас мөлгөржсөн хэмхдэс чулуулаг агуулсан бор саарал өнгийн элсэнцэр, улаан хүрэн өнгийн шавраар хучигдсан. Хучаас хурдасны дундаж зузаан нь 13.0 м, Элсний давхаргын зузаан 1.6 м. Хөрс хуулалтын итгэлцүүр 6.0 м байна.

Ордын орчим ой мод, хад асга, намаг байхгүй элс хөрсний овоолго байгуулах талбай хангалттай бөгөөд орон нутгийн тусгай хэрэгцээний болон улсын тусгай хамгаалалттай газрын талбайд хамаарахгүй. Баруун Захцагийн орд нь агуулга сайтай, эдийн засгийн байршил сайн зам харилцаа дэд бүтэц өндөр хөгжсөн алтны олборлолт эрчимтэй явагдаж байгаа дүүрэг оршдог. Олборлолтын болон уул техникийн хүндрэлгүй юм үүний зэрэгцээ бул чулуулаг багатай элсний угаагдах чанар сайн. Тухайн онд олборлолтын явцад уурхайн ухаанд ус шүүх зайлуулах ажил хийгдээгүй ба цэвдэгт хурдас байхгүй зэрэг нь ордын уул-техникийн нөхцөл энгийн ашиглахад хялбар орд юм.



Зураг. Ил уурхайн 2023 оны ашиглалт үйл ажиллагаа

ХОЁР. 2023 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Баруун Захцагийн алтны шороон ордод 2011 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж ажлын байр бий болгож, Монгол улсынхаа хөгжил дэвшилд зохих хувь нэмрийг оруулан ажиллаж байна. Уурхайн ашиглалтыг ил аргаар, экскаватор-автосамосвал хослосон тээвэртэй ашиглалтын технологиор явуулж байна.

2023 онд уулын ажлыг Баруун захцагийн ордын В-II-5 блок, В-II-4 блокын хэсэглэлд явуулан шинээр 3.0 га талбай уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон. Уурхайн үйл ажиллагааны улмаас өссөн дүнгээр нийт 123.0 га талбай эвдрэлд орсон.

Уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Төлөвлөлтийн тоон утга	Гүйцэтгэлийн тоон утга	Тайлбар
1	2	3	4	5	6
1	Олборлолт				
1.1	Хөрс хуулалт, ил уурхай	мян.м ³	422.71	245.386	
1.2	Олборлосон элсний хэмжээ	мян.м ³	41.54	32.348	
1.3	Металл авалт	%	95	95	
1.4	Дундаж агуулга	гр/м ³	0.32	0.3	
2	Бүтээгдэхүүн гаргалт				
2.1	Боловсруулсан элсний хэмжээ	мян.м ³	41.54	32.348	
2.2	Алт (Гулдмай)	кг	12.72	10.0	

Шимт хөрс.

Уурхайн үндсэн хөрс хуулалтын ажлыг эхлүүлэхийн өмнө В-II-5 блокын 30.1 мян.м² талбайгаас дундажаар 0.65 метр зузаан 19.804 шимт хөрсийг техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд шууд тараан хучилт хийж биологийн нөхөн сэргээлт хийхэд үе шатанд оруулсан. Энэ онд шимт хөрсний овоолго үүсгээгүй бөгөөд өмнөх онуудын уурхайн хэмжээнд үүсгэсэн зургаан хэсэг шимт хөрсний овоолгын шим, ялзмагыг алдагдуулахгүйн тулд хуурайшилттай үед услагаа хийж чийгшүүлж байсан.

Монгол улсад мөрдөгдөж буй “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS 5916:2008 стандартын дагуу уурхайн ашиглалт явагдах талбайн шимт хөрсийг ашиглалт явуулахын өмнө хуулж бэлтгэн нөхөн сэргээлтийн үе шатанд ашиглахаар овоолго үүсгэн хадгалаж байна.

Уулын ажил:

2023 онд уулын ажлыг ордын В-II-5, В-II-4 блокуудад хийж гүйцэтгэлээ. Тус блокуудаас нийт 245.386 мян.м³ хөрс хуулалт хийж, 32.348 мян.м³ элс олборлосон. Уулын ажил явуулсан блокуудын хөрсний зузаан дунджаар 12.0 м, алт агуулсан давхаргын /элс/ зузаан дунджаар 1.6 м байсан. Хөрс хуулалтын ажлын доголыг 2.5-3.0 метр өндөртэйгөөр Н_{мө}-1, Н_{мө}-2, Н_{мө}-3, Н_{мө}-4 гэсэн түвшингээр ахилтыг явуулсан.

Элс олборлолтын дараах хоосон зайд хөрсийг дотоод овоолго хийх технологиор ашиглаж байгаа нь хөрсний эвдрэлийг багасгах, нөхөн сэргээлтийг ашиглалтын явцад гүйцэтгэх, агаарт тоос шороо дэгдэх зэрэг сөрөг нөлөөллийг бууруулан ажиллаж байна.

Баяжуулалт, боловсруулалт бүтээгдэхүүн гаргалт.

Угаах үйлдвэр нь ил уурхайгаас олборлосон алт агуулсан элсийг угаан баяжуулах, уурхайн хэмжээнд бүтээгдэхүүн гарган авах эцсийн дамжлаг юм.

Элс угаан баяжуулах ажлыг Шинэ Зеланд улсад үйлдвэрлэсэн NZMining systemS-120 маркын скруббер /угаах төхөөрөмж/-ын тусламжтайгаар гүйцэтгэсэн. Угаах төхөөрөмжийг өмнөх онд ашиглаж байсан үйлдвэрийн болон хаягдлын санг түшиглэн байрлуулан баяжуулалтын явцад дүүргэлт хийх аргаар нөхөн сэргээлт хийж ажилласан. Ил уурхайгаас ирэх -100 мм ширхэглэлтэй анхдагч элсийг скрубберт оруулж сайтар угааж задалсаны дараа 20 мм-ийн диаметртэй тороор шигшигдэж +20-100 мм ангилалын бүтээгдэхүүн нь галийн овоолгод хаягдана. -20+0 ангилалын бүтээгдэхүүн нь хоригт цоргод тэжээгдэнэ. Скруберээс гарсан +20 -100 мм ширхэглэлтэй бүтээгдэхүүн нь галийн овоолгод хаягдана. Хоригт цорго болон тунаах машинаас гарсан хаягдал нь эфелийн овоолгод тус тус хаягддаг.

Үйлдвэрийн болон хаягдлын сан. В-1-8 блокод байрлах өмнөх онд ашиглаж байсан үйлдвэрийн болон хаягдлын санг үргэлжлүүлэн ашигласан ба баяжуулалтын явцад эфель галийн хаягдлаар дүүргэлт хийж техникийн нөхөн сэргээлтийг хийсэн.

8 дугаар сарын 10-нд угаах төхөөрөмжийг нүүлгэж шинээр байгуулсан үйлдвэрийн санд байрлуулан баяжуулалтын ажлыг гүйцэтгэсэн.

Үйлдвэрийн болон хаягдлын санг ашигласан талбайд байгуулж баяжуулалтын явцад галиар тунаан цэвэршүүлж угаах үйлдвэрт дахин эргүүлэн ашигладаг тул хаягдал булингатай усыг хүрээлэн буй орчинд нийлүүлдэггүй.

Усан хангамж. Уурхайд ашиглагдах унд ахуйн болон үйлдвэрлэлд ашиглагдах усыг зориулалтаас хамаарч дараах эх үүсвэрээс хангаж байна. Үүнд:

1. Унд, ахуйн хэрэглээнд-гүний худаг
2. Элс угаан баяжуулахад-Туул гол

Байгаль орчныг хамгаалах, усны нөөцийг хэмнэх зорилгоор угаан баяжуулах технологиос гарсан усыг үйлдвэрийн болон хаягдлын санд тунаан эргүүлэн ашиглаж байна. Өмнөх онд ашиглаж байсан хаягдлын санг 8 сар хүртэл ашиглан эфель галиар дүүргэлт хийсэн ба шинээр байгуулсан үйлдвэрийн усан сан руу угаах төхөөрөмжийг суурьлуулан технологийн усыг Туул голоос 930 м урт 200 мм-ийн диаметр бүхий PVC уян усны хоолойгоор Hitachi Z350 маркийн насосоор ус татаж ажилласан.

Усны тухай хуулийн 30.1.4 дүгээр зүйл, Ус ашиглах гэрээний 2.8 дүгээр заалт, “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ын дагуу Гүний худагт LXSG-25E маркийн цагт 3.5 м.куб ус шахах хүчин чадал бүхий усны тоолуур, Туул голоос ус татах насос нь дээр БНХАУ-д үйлдвэрлэсэн ННD-150K1G1ET1P2D3J1EN маркийн 200 мм-ийн голчтой цахилгаан соронзон /Electromagnetic/ усны тоолуурыг 5-р сараас 10-р сар хүртэл суурьлуулан ажилласан.

Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомстох, бохирдохоос сэргийлэн Булган аймгийн Бүрэгхангай сумын засаг дарга, байгаль орчны байцаагч нараас Дархан багийн жинстийн эх булаг /рашаан/-ийг хашиж хамгаалах саналын дагуу булгийн эхийг хамгаалж 60 м урт хайсан хашаа хийв.



Зураг. Амралтын эхийн булаг

Ус ашигласны төлбөрийн хэмжээ:

Ашигт малтмал баяжуулахад ашиглах 130560.0 м³, гадаргын ус ашигласны төлбөрт 77875776.0 төгрөг, зам талбайн усалгаанд ашиглах 3240.0 м³ гадаргын ус ашигласны төлбөрт 257677.0 төгрөг, биологийн нөхөн сэргээлтэд, ашиглах 8208.0 м³ гадаргын ус ашигласны төлбөрт 152316.0 төгрөг, нийт ус ашигласны төлбөрт 78285769.0 төгрөгийг Булган аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлсэн.

6/29/22, 3:35 PM Гүйлгээний баримт

Татвар төлбөр		Огноо: 2022-06-29 15:34	
КАПИТРОН БАНК- Most Money Татвар төлөлт		№ : 112568953	
Хүлээн авагч:	Булган	Хүлээн авсан данс:	100040000944
Төлөгч РД:	60001062358001	Гүйлгээний суваг:	Банк Интерфэйс
Биллийн дугаар:	3220602663263		
Татварын мэдээлэл			
Эзэмшигч:	ГБНБ	Татварын төрөл:	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр
Утас:		Хөрөнгийн дугаар:	Тайлант хугацаа: 2022
Төлбөр хийсэн данс :		Төлөх дүн: 0	
Гүйлгээний утга : 3220602663263 60001062358001 ГБНБ		Нийт төлсөн дүн : 35073111	
		1. ММ: ТАТВАР ТӨЛБӨР:[500.00MNT]	
Татвараа хугацаанд нь төлсөн танд баярлалаа. Татвартай холбоотой асуудал байвал дараах хаягаар хандана уу! 1800-1288, INFO@MTA.MN.			
Хянасан :	Теллер :	Харилцагч :	

Цахилгаан хангамж. Баруун захцаг уурхайн үндсэн тоног төхөөрөмж, угаах үйлдвэр нь өөрийн эх үүсвэр болох дизель хөдөлгүүртэй, цахилгаанаас үл хамааралтай ажилладаг. Уурхайн нь төвийн цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй тул уурхайн хотхон болон засварын хэсгийг дизель генератор ашиглан цахилгаанаар хангадаг.



Зураг: Уурхайг цахилгаанаар хангаж буй дизель генератор

Нөхөн сэргээлтэд ашиглагдсан техникүүд.

2023 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажилд дараах техникүүдийг ашигласан.

- ❖ JHONO DEERE 850J- маркийн бульдозер - 1 ш
- ❖ Fiat ALLS-F32 маркын бульдозер – 1 ш
- ❖ Гараар хийсэн борноо – 1 ш
- ❖ 2 м.куб шанаганы багтаамж бүхий Hitachi-ZAXIS 470-LCH, 450-LC маркын экскаватор болон ачигч техникүүд -2 ш
- ❖ 13-18 м.куб багтаамж бүхий VOLVO-A25C, FM-440 маркын автосамосвал - 5 ш зэрэг техник тоног төхөөрөмжүүдийг ашиглаж хоногт 2.0-5.0 мян.м3 хөрс шилжүүлэн уулын ажлын явцад нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэлээ.



Зураг. Нөхөн сэргээлтэд ажилласан техникүүд

Шороон ордыг ашиглахдаа дотоод овоолгоор тээвэртэй ашиглалтын системээр явуулсан. Ашиглалтын явцад үүссэн хоосон орон зайд дотоод овоолго байгуулах замаар, тээврээр ирж байгаа хөрсийг сайн шахаж асгуулан талбайн хэмжээ гүйцсэн тохиолдолд бульдозероор түрж тэгшлэн өндөрлөж овоолгыг байгуулахдаа машин техникийн бүтээлийг дээшлүүлэх, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор тээврйн зам, хамгаалалтын үе хөмсгийг журам зааврын дагуу хийж гүйцэтгэсэн. Уулын ажлыг ил аргаар ашиглалт болон баяжуулалтын явцад дотоод овоолготойгоор явуулж байгаа нь нөхөн сэргээлтийг олборлолтын явцад зэрэг гүйцэтгэхээс гадна байгаль орчинд учрах сөрөг нөлөөлөлийг багасгах, уулын ажилд өртөгдөж эдрэлд орох талбайг багасгах, газрын хөрс эвдрэч доройтох, ургамал дарагдах, тоосжилт үүсэх зэрэг сөрөг нөлөөлөлийг зохих хэмжээгээр бууруулан ажиллаж байна.

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1 Агаар орчныг хамгаалах

Баруун Захцагийн алтны шороон ордыг ашиглах явцад их хэмжээний нутаг дэвсгэрийг хамарсан байгаль орчин бол хүн, амьтанд нөлөөлөхүйц хэмжээний сөрөг нөлөөлөл үүсэхгүй гэж үзэж байна. Баруун захцагийн алтны шороон орд нь 252.0 га эдэлбэр газартай бөгөөд үүний 123.0 га талбай нь уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон. Эвдрэлд орсон талбайн 85 хувийг нөхөн сэргээсэн тул сөрөг нөлөөлөл тодорхой хэмжээнд буурч байгаа юм.

Уулын ажлын явцад технологийн зам талбайд сул шороо босч агаар бохирдуулах нөхцөл үүсдэг тул уурхайн тосгон, технологийн зам, талбайг өдөрт 3-5 удаа 4 дүгээр сараас 11 дүгээр сарын хооронд усалж чийгшүүлж байсан. Технологийн зам талбайг 8.0 тонны багтаамжтай ОХУ-н үйлдвэрлэсэн камаз маркийн усны машиныг ашиглаж байна.



Зураг: Тоосжилтыг бууруулах зорилгоор зам чийгшүүлж буй байдал

Машин техникүүд ил уурхайд хурдтай давихсаны улмаас агаарт тоосжилт үүсэхээс сэргийлэн технологийн замд хурд хэтрүүлэхийг хориглож, хурдны дээд хязгаарын тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн байрлуулж ажилласан.



Уурхайн гал зууханд гал түлэх утаа үүсгэхээс татгалзаж хийн зуухыг 2019 оноос хойш тасралтгүй ашиглаж байна.

Хүнд автомашин, техник тоног төхөөрөмжөөс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах, агаарт хар утаа үүсгэх зэргээс сэргийлж хар утаа гаргаж буй автомашин, тоног төхөөржийг зогсоож засвар үйлчилгээг хийх, техник тоног төхөөрөмжүүдийн хөдөлгүүрийн мото цагийн үйлчилгээ 200, 500, 1000 мото/ц хугацаанд хийж байсан.

Уурхайн энгийн хог хаягдлын цэг, ажилчдын усан орох газар /саун/, нийтийн бие засах газар зэргийг 15 хоногт 1 удаа белизна, шавлени, хлорын 5-10%-ийн сүүн уусмалаар ариутгадаг.



Уурхайн дотоод тээврийн зам, техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөнөөс нарийн ширхэгт шороо тоос агаар мандалд дэгдэх, тоосжилт үүсэхгүй байх үүднээс байнгийн хэрэглэгддэг замыг эфель, галиар дэвсэж засаж сайжруулах ажлыг байнгын хийж байна. Хөрсийг ашиглалтын явцад ашиглагдсан орон зайд дотоод овоолго үүсгэн явуулж байгаа нь агаарт шороо тоос босохоос сэргийлж байна.



3.2 Усны нөөц, чанарыг хамгаалах

Баяжуулах үйлдвэрийн технологийн усны хэрэглээг туул голоос хангаж байгаа ба үйлдвэрийн болон хаягдлын санд хуримтлагдсан булингартай усыг тунаан цэвэршүүлж эргүүлэн элс угаахад ашиглахаас гадна нөхөн сэргээлт болон зам талбай услахад ашиглаж байна.

- Уурхайн ажилчдын унд, ахуйн зориулалттай гүний худагт LXSG-25E маркийн цагт 3.5 м.куб ус шахах хүчин чадалтай усны тоолуур суурьлуулсан.
- Туул голоос ус татах насосонд 150 мм-ийн голчтой HHD-150K1G1ET1P2D3J1EN маркийн цахилгаан соронзон /Electromagnetic/ усны тоолуур суурьлуулсан.

Усны тоолуурын заалтыг сар бүр тэмдэглэж тэмдэглэл хөтөлж ирсэн.




Зураг. Тоолуур суурьлуулсан байдал

Өмнөх онд ашиглаж байсан В-1-8 блокод байрлах хаягдлын санг үргэлжлүүлэн ашигласан ба булингартай усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхгүйн тулд шинээр байгуулсан үйлдвэрийн сан руу татсан. тус хаягдлын санг эфель галийн хаягдлаар дүүргэлт хийж нөхөн сэргээсэн тул тунаан шүүх далан хийх шаардлага гараагүй.

Харин 8 дугаар сараас үйлдвэрийн болон хаягдлын санд хуримтлагдсан усыг тунаан шүүж эргүүлэн угаах процест ашигласан. Шинэ үйлдвэрийн болон хаягдлын сангийн усны нөөц багассан тохиолдолд туул голоос сэлбэн ажиллаа. Тус хаягдлын санд ирэх жилээс тунаан шүүх зориулалттай далан байгуулах юм.

Туул голоос 150 мм-ийн диаметртэй, 930 метр урт уян /PVC/ хоолойгоор угаах төхөөрөмж рүү ус дамжуулдаг. Усны хомсдол алдагдалаас сэргийлж ус дамжуулах шугам хоолойн ашиглалтад хяналт тавих ба усны хоолой гэмтсэн тохиолдолд насосыг унтрааж засвар үйлчилгээг тухай бүрд нь засах арга хэмжээг шуурхай авч хэвийн ажиллагаанд оруулдаг.



Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомстох, бохирдохоос сэргийлэн Булган аймгийн Бүрэгхангай сумын засаг дарга, байгаль орчны байцаагч нараас Дархан багийн жинстийн амандахь булаг/рашаан/-ийг хашиж хамгаалах саналын дагуу булгийн эхийг хамгаалж 60 м урт хайсан хашаа хийв.



Зураг. Жинстийн рашааныг хамгаалсан байдал

3.3 Хөрс хамгаалах

Монгол улсын газрын тухай хуулийн дагуу Баруун захцагийн алтны шороон ордын 8998А тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн газар ашигласны төлбөрийг Бүрэгхангай сумын төрийн банкны дансанд төлсөн. Уулын ажлыг төлөвлөлтийн дагуу тогтоогдсон геологийн блокоос өөр газар газрын хэвлийг ухах, гадаад овоолго хийгээгүй бөгөөд тус онд 3 га талбай уулын ажилд өртсөн. Уулын ажил явуулах В-2-4 блокын шимт хөрсийг экскаватор-автомашин ашиглан хуулж техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд хучилт хийж биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлтгэсэн.




Зураг. Шимт хөрс хуулж буй байдал

Шимт хөрсний овоолгыг MNS стандартын дагуу үерийн уснаас хамгаалан суваг шуудуу татсан. Удаан хугацаанд шимт хөрсийг хадгалдаггүй учир шимт хөрсний үржил шимийг хадгалах ажил хийгдээгүй.

Хөрсний бохирдолоос сэргийлж засварын талбайд галь /хайрга/ дэвсэж хучилт хийсэн.



Хүнд машин механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг засварын талбайд хийж гүйцэтгэдэг ба засвар үйлчилгээнээс гарсан хаягдал тос маслыг тусгай саванд хийж хадгалаж байна.



Хүнд машин механизмаар уурхайн орчимд олон салаа зам гаргаж хөрсний эвдрэл элэгдэл үүсдэг. Үүнийг багасгахын тулд машин механизмыг тогтсон нэг замаар явуулж замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан.

Уурхайн хотхон болон засварын талбайн хог хаягдлыг ангилан ялгаж, их цэвэрлэгээг долоо хоногт нэг удаа хийдэг.



Зураг. Уурхайн хотхон, засварын талбайг цэвэрлэж буй байдал

3.4 Газрын хэвлий

2023 оны уулын ажлыг В-2-5, В-2-4 блокын нөөцийг олборлохоор төлөвлсөн хэдийч уурхайн ажиллах хүчний дутагдалтай байдлаас шалтгаалж В-2-5 блокыг бүрэн олборлож, В-2-4 блокын тодорхой хэсэгт олборлолт хийгдээгүй үлдэж байгаа.

Олборлолт явуулсан талбайд дотоод овоолгоор 10 га талбай нөхөн сэргээсэн.

3.5 Ургамлан нөмрөг

Энэ онд уулын ажилд 3 га талбай өртсөн ба шимт хөрсийг тусад нь хуулж авч техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг хучсан. Уурхайн дотоод тээвэрийн маршрутыг мөрдүүлэн ургамалн нөмрөг устгахаас сэргийлж ажилласан.

Биологийн нөхөн сэргээлтэд олон наст (Ерхөг, Согоовор, Өлөнгө), малын тэжээлийн зориулалтаар цагаан арвай, буудай, овьёос зэрэг 2000 кг холимог үрийг гараар тариалж борноодсон.



Уурхайн ашиглалтын талбайг тойруулан татсан сувагт мал, амьтан унах, орохоос сэргийлэн сэргээн зассан.



Төслийн эдэлбэр газарт нурж, онгоосон өрөмлөгийн 6 нүхийг шороо чулуугаар дүүргэж нөхөн сэргээсэн.



СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт: 11

1. АГААРЫН ЧАНАР					
№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Гүйцэтгэл	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Хөрс хуулалт, тээвэрлэлтээс тоосжилт бий болдог	Уурхайн технологийн зам, талбайг тогтмол чийгшүүлж услах	Ил уурхайд	Уурхайн кемп, ажлын талбай, тээврийн зам зэргийг 8 тн усны машинаар өдөр бүр 3-5 удаа чийгшүүлж усалдаг. Бороотой үед усалгаа хийдэггүй байгаа.	“Байгаль орчныг хамгаалах тухай” хууль; Агаарын чанарын стандарт. MNS 5457: 2005
2	Машин, техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Уулын ажилтай уялдуулан тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах, эвдрэлтэй зам талбайг засах, арчилах	Ил уурхайд	Хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглэгээ байрлуулан, Тээврийн хэрэгслүүдэд GPS суурьлуульж хяналт тавьж байна. Хог хаягдлын цэг, ажилчдын усан орох газар /саун/, нийтийн бие засах газар зэргийг 15 хоногт 1 удаа белизна, шавлени, хлорын уусмалаар ариутгадаг.	
2. УСНЫ НӨӨЦ, ЧАНАР					
1	Усны төлөвлөлтийг зөв оновчтой гаргаагүйгээс усны нөөц хомсдох	Гүний худаг, Туул голоос ус татах насоснд тоолуур суурилуулах, тэмдэглэл хөтлөх	Усны насос	Гүний худагт LXSG-25E, Усны насоснд ННД-150К1 маркийн цахилгаан соронзон тоолуур суурьлуулсан. Тоолуурын заалтыг сарын эцэст тэмдэглэж байсан.	“Усны тухай” хууль; Усан орчны чанарын үзүүлэлт. MNS4596:1998, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар, хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2015
2		Үйлдвэрийн болон хаягдлын сангийн уснаас нөхөн сэргээлт, зам усалгаанд ашиглах	Уурхайд	Зам талбай услах, биологийн нөхөн сэргээлтэд хаягдал сангийн усыг ашигласан.	
3	Технологийн ус алдагдаж, хөрсөөр дамжин газрын доорх усыг бохирдуулж болзошгүй	Хаягдлын санд тунаан шүүх далан байгуулах, хаягдал усыг эргүүлэн ашиглах,	Хаягдлын сан	В-1-8 блокод байрлах хаягдлын санг эфель галь хийж нөхөн сэргээсэн тул шүүх далан хийгээгүй.	
4		Ус дамжуулах хоолойд хяналт тавьж, засах	Уурхайд	Ус дамжуулах хоолой задарсан үед угаалгийг зогсоож засвар үйлчилгээг тухай бүрд хийж хэвийн ажилласан.	

3. ХӨРСӨН БҮРХЭВЧ					
№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Гүйцэтгэл	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	Ургамлын нөмрөг устах, дарагдах, нөлөөлөлд өртөж доройтох	В-2-4 блокоос шимт хөрсийг хуулах, овоолго үүсгэнэ.	Төслийн талбайд	Шимт хөрсний овоолго үүсгэлгүй В-2-4 блокын шимт хөрсийг хуулж техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн 6.2 га-г шимт хөрсөөр хучсан.	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт. MNS 5916:2008
2	Шимт хөрсний овоолго салхи, усны нөлөөгөөр элэгдэхээс сэргийлэх. Машин механизмийн шатахуун, тос	Машин механизмийн засвар, үйлчилгээг засварын талбайд хийх Хаягдал тос, ШТМ-ыг тусгай саванд хадгалах.	Засварын талбай	Засварын талбайд галь /хайрга/ дэвсэж хучсан ба тус талбайд хүнд машин механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэдэг. Засвар үйлчилгээний хаягдал тос маслыг тусгай саванд хийж хадгалан гэрээт компанид нийлүүлдэг.	“Хог хаягдлын тухай” хууль Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
3	масло, шингэнэ асгарах хөрс бохирдох	Уурхайн хотхон, засварын талбайд цэвэрлэгээ хийх	Төслийн талбай	Уурхайн хотхон болон засварын талбайн хог хаягдлыг ангилан ялгаж, их цэвэрлэгээг долоо хоногт нэг удаа хийдэг.	
4. ГАЗРЫН ХЭВЛИЙ					
	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх	Уулын ажлыг төлөвлөсөн блокуудад явуулах.	Төслийн талбай	2023 оны уулын ажлыг В-2-5, В-2-4 блокын нөөцийг олборлохоор төлөвлөсөн хэдийч уурхайн ажиллах хүчний дутагдалтай байдлаас шалтгаалж В-2-5 блокыг бүрэн олборлож, В-2-4 блокын тодорхой хэсэгт олборлолт хийгдээгүй үлдэж байгаа.	

5. УРГАМЛАН НӨМРӨГ					
1		Уулын ажлыг дотоод овоолгойтойгоор зохион байгуулан, уулын ажилд өртөөгүй талбайд шороон асгац асгахаас сэргийлэх	Уулын ажлын хүрээнд	Уулын ажилд энэ онд 3 га талбай өртсөн ба Уулын ажилд өртөөгүй талбайд шороо асгах, овоолго үүсгээгүй.	Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль
2	Ургамлын нөмрөг устах, дарагдах, нөлөөлөлд өртөж доройтох	Олон салаа зам гарахаас сэргийлж тогтоосон нэг замаар явах, Тэмдэг тэмдэглэгээ байрлуулах	Төслийн талбайд	Дотоод тээвэрийн хоёроос 3 зам гаргаж, Ургамлан нөмрөг хөндөхгүйн тулд замын маршрутыг уурхайд мөрдүүлж ажилласан. Замын тэмдэг тэмдэглэгээг уулын ажилтай уялдуулан байрлуулсан.	
3		Биологийн нөхөн сэргээлтэд олон төрөл зүйлээс бүрдсэн ургамлын үр тариалах	Нөхөн сэргээлтийн талбай	Биологийн нөхөн сэргээлтэд олон наст (Ерхөг, Согоовор, Өлөнгө), малын тэжээлийн зориулалтаар цагаан арвай, буудай, овъёос зэрэг 2000 кг холимог үрийг гараар тариалсан.	
6. АМЬТАНЫ АЙМАГ					
1	Уурхайн ухаш, хаягдлын сан, хайгуулын	Ил уурхайг тойруулан татсан сувгийг сэргээн засах	Ил уурхайд	Уурхайн ашиглалтын талбайг тойруулан татсан сувагийг мал, амьтан орохоос сэргийлж сэргээн зассан.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
2	цооногт мал амьтан орж үхэх, унах аюултай.	Төслийн талбай дахь нурж онгойсон цооногуудыг бөглөж нөхөн сэргээх	Төслийн талбайд	Компаний эдэлбэр газарт нурж, онгоосон өрөмлөгийн 6 нүхийг шороо чулуугаар дүүргэж нөхөн сэргээсэн.	Байгаль орчин нөлөөллийн үнэлгээ

ДӨРӨВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Бид нөхөн сэргээлтийг хийхдээ Монгол улсад мөрдөгдөж буй “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5914:2018, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2018, Эвдэрсэн газрыг ургамалжуулах. техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2018 стандартуудын дагуу хийж гүйцэтгэхээр зорьж ажиллаж байна.

MV-008998 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баруун захцагийн орд нь 252.02 га талбайтай бөгөөд энэ онд 3 га талбай уулын ажилд өрстөн ба 2011 оноос хойш өссөн дүнгээр нийт 123.0 га талбай уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрэлд ороод байна. Энэ оны газар ашигласны төлбөр болох 38.0 сая.төг Булган аймаг болон Бүрэгхангай сумын төрийн санд тушаасан.

4.1 Техникийн нөхөн сэргээлт

Техникийн нөхөн сэргээлтийн технологийг олборлолт, хөрс хуулалт, дотоод овоолго үүсгэлт зэрэг уулын ажлын технологитой харилцан уялдуулж гүйцэтгэх нь хосолмол аргаар илүү их нөхөн сэргээлтийн ажил явуулах, нөхөн сэргээлтийн зардлыг бууруулах зэрэг боломжийг бүрдүүлдэг.

Ашиглалтын явцад 9.7 га талбайг 87.386 мян.м³ хөрсөөр хэлбэржүүлэн дүүргэж нөхөн сэргээсэн.



Зураг. Ашиглалтын явцад дотоод овоолго хийж буй байдал.

Техникийн нөхөн сэргээлтийг өмнөх онд дотоод овоолгоор дүүргэлт хийсэн талбайг үргэлжлүүлэн гүйцэтгэсэн. “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5917:2008 стандартаар газрын гадаргын анхдагч хэлбэрт оруулж, тэгшлэн биологийн нөхөн сэргээлтэд бэлэн болгосон.

2023 онд В-I-7, В-I-8, В-I-14, В-I-15 дугаартай блокуудын **11.5-га** талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. Техникийн нөхөн сэргээлтийг уулын ажлын болон баяжуулалтын явцад 2 үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн.

1. Хаягдлын сан-нөхөн сэргээлт.

Өмнөх онд ашиглаж байсан хаягдлын санг /В-1-7/ уулын ажлын явцад хөрсөөр дарж тэгшлэсэн ба энэ онд ашигласан хаягдлын санг /В-1-8/ баяжуулалтын явцад 32.5 мян.м³ эфель галийн хаягдалаар дүүргэлт хийж нөхөн сэргээсэн. 1.8 га хаягдлын санг нөхөн сэргээсэн.



Зураг. Хаягдлын сан /нөхөн сэргээлтийн өмнө/



Зураг. Хаягдлын санг нөхөн сэргээж буй байдал

2. Шимт хөрсний нөхөн сэргээлт:

Техникийн нөхөн сэргээлт хийсэн 11.5 га талбайн 6.2 га талбайг 19.8 мян.м³ шимт хөрсөөр хучилт хийж ургамалжуулахаар бэлтгэсэн.



Зураг. Шимт хөрсөөр хучилт хийж буй байдал



Зураг. Техникийн сэргээлт хийсэний дараа

4.2 Биологийн нөхөн сэргээлт

Тус онд гурван хэсэглэлд нийт 6.2 шимт хөрсөөр хучсан талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн. Нөхөн сэргээлтийг хөдөө аж ахуйн бэлчээрийн зориулалтаар ашиглахаар төлөвлөсөний дагуу 6.2 талбайд олон настын үр (Ерхөг, Согоовор, Өлөнгө) болон цагаан арвай, буудай, овъёос зэрэг 2780 кг холимог үрийг тариалсан.



Нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн эдэлбэрийн байгаль орчны суурь нөхцөл байдлыг тодорхойлон ургамлын үрийг гар аргаар тариалж, техникээр борноодон байгалийн аясаар ургамалжуулав.





Зураг. Биологийн нөхөн сэргээлт хийхийн өмнө



Зураг. Биологийн нөхөн сэргээлт хийсэний дараа

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөлт				Гүйцэтгэл			
	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Эзэлхүүн мян.м3	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Эзэлхүүн мян.м3	Зураг
Техникийн нөхөн сэргээлт								
1	Дотоод овоолго	га	8.1	-	га	9.7	87.4	
2	Үйлдвэрийн болон хаягдлын сан	га	0.6	30.0	га	1.8	32.5	
3	Шимт хөрсөөр хучих	га	8.7	26.1	га	6.2	19.8	
	Нийт	га	8.7		га	11.5		
Биологийн нөхөн сэргээлт								
3	Олон настын ургамал тарих	га	5.3	-	га	6.2		

ТАВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Монгол улсын Засгийн газрын 2020-2023 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8 дахь заалт “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ” гэсэн зорилтын хүрээнд Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрт эвдэрч орхигдсон нөхөн сэргээлт хийгдээгүй талбайд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгаас санал авсаны дагуу MV-008998 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн урд хэсэгт, Туул голын эрэг дагуух эвдрэлд орсон 5.0 га талбайг өөрийн эзэмшлийн техникийг ашиглан нөхөн сэргээлт хийсэн.



Зураг. Нөхөн сэргээлт хийхийн өмнө



Зураг. Нөхөн сэргээж буй байдал



Зураг. Дүйцүүлэн хамгаалж нөхөн сэргээсэн талбай

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэл

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Төлөвлөлт		Гүйцэтгэл	
			талбай /Га/	Хэмжээ /мян.м ³ /	талбай /Га/	хэмжээ /мян.м ³ /
1	Эвдэгдсэн газрыг налууулж, хэлбэршүүлэн хүн, мал амьтан явахад аюулгүй болгох, үржил шимт давхарга үүсгэх	Техникийн нөхөн сэргээлт хийх	5.0	70.0	5.2	58.3

5.1 “ТЭРБУМ МОД” ТАРИХ ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд манай хамт олон уурхайн эдэлбэр талбайд арчилгаа бага шаардагддаг 2300 ширхэг хайлас мод тарьв. Мод тарих нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангахад чухал ач холбогдолтой.



Зураг. Мод суулгаж буй байдал

Мод тарих төлөвлөгөөний гүйцэтгэл

Хүснэгт .

№	Зорилт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		
		Тоо хэмжээ /ширхэг/	Зардал /сая.төг/	Тоо хэмжээ /ширхэг/	Зардал /сая.төг/	Төрөл
	Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах	3000	10.0	2300	-	Хайлаас

**ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Баруун Захцагийн шороон ордын MV-008998 тусгай зөвшөөрөл бүхий талбайд барилга байгууламж, объект болон үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, ард иргэд байхгүй учир нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгөөнд тусгагдаагүй.

**ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**


Баруун Захцагийн шороон ордын MV-008998 тусгай зөвшөөрөлтэй талбайд археологи, палеонтологи, түүх, соёлын дурсгалт газар байхгүй болно. Тиймээс түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгөөнд тусгаагүй.

Энэ онд үйл ажиллагааны явцад археологи, палеонтологи, түүх , соёлын дурсгалт зүйлийн илэрц олдвор гарах тохиолдолд тухайн үйл ажиллагааг зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэн шаардлагатай арга хэмжээг авахуулна.



НАЙМ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Гэнэтийн осолд урьдчилан тооцоолоход нэн бэрх байгалийн гамшигт үзэгдлүүдийг хамруулан үзэх бөгөөд үүнд усны үер, хүчтэй газар хөдлөл, аянга цахилгаан зэргийг үзнэ. Аваар осолоос сэргийлж дараах болох тохиодолд төслийн хүрээнд байгаль орчныг бохирдуулах зэрэг хохирол учруулах нь харьцангуй их байдаг

- ❖ Баруун захцагийн уурхайн гамшиг, осолын үед дагаж мөрдөх АЮУЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨГ боловсруулан уул уурхайн аврах албаар хянуулан батлуулж мөрдлөг болгон ажилласан.
- ❖ Нийт ажилчдыг Натул эмнэлэгт 2023 оны 04 дүгээр сарын 03–нд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулан, Уурхайн ажлын явцад ажилчдад мэргэжилээс шалтгаалсан өвчлөлөөс сэргийлэн эмч ажилуулсан.
- ❖ ХАБЭА-н урьдчилсан сургалтыг мэргэжлийн байгуулагатай хамтран 4 сарын 05-нд зохион байгуулж уурхайн нийт ажилчдыг хамруулсан.
- ❖ Уурхайн ажлын байранд осол, эрсдлийн үнэлгээг 6 дугаар сард хийж, болзошгүй аюул ослоос сэргийлэн ажилласан.



- ❖ ХАБЭА-н ажлын байрны АА-ны өдөр тутмын зааварчилгааг өдөр бүр ажилд гарахын өмнө, Давтан зааварчилгааг сар бүр өгч гарын үсэг зуруулан баталгаажуулж байсан.
- ❖ Гал түймэрийн аюулаас сэргийлэн галын хор, гал унтраах багаж хэрэгсэлийг уурхайн кемп, ШТС, засварын хэсэг, техник тоног төхөөрөмжүүдэд байрлуулан тэмдэг тэмдэглэгээг тавьсан.



- ❖ Энэ онд уулын ажлыг нэг ээлжээр буюу өдрийн цагаар явуулсан тул ил уурхайд гэрэлтүүлэг тавиагүй.
- ❖ Уурхайн ажлын талбар, технололгийн зам, засварын хэсэг, үйлдвэрийн болон хаягдлын сан зэрэг аюултай хэсэгт анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулан ажилласан.



- ❖ Үер усны аюулаас сэргийлж ил уурхайн ирмэгээр хамгаалалтын шороон далан хийсэн. Нөхөн сэргээсэн талбайгаас үерийн ус ил уурхайруу эрсдэлтэй байсан тул нөхөн сэргээсэн талбайг тойруулж ус тогтоох зориулалтай хамар хийсэн.



- ❖ Хайлаастай жалгын дагуу үерийн ус зайлуулах суваг татаж, сувгийг бэхжүүлж чулуун далан хийсэн.



ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Хэрэгжүүлсэн ажил	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үйлдвэрийн аваар, осол, саатал гэмтэл бүр төслийн үйл ажиллагаанд эдийн засгийн ихээхэн хохирол учруулдгаас гадна ажиллагсдын эрүүл мэнд болон амь насанд хохирол учруулах, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх аюултай.	ХАБЭА-н урьдчилсан сургалт, эрүүл мэндийн үзлгийг ажилд гарахын өмнө 4 сард зохион байгуулж уурхайн ажилчдыг хамруулсан. ХАБЭА-н сургалтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.	Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хууль
2		Ажилчдыг ХХ-ын хувцас, хэрэгсэлээр ханган ажилласан Ажлын байрны АА-ны зааварчилгааг өдөр тутам өгсөн. Давтан зааварчилгааг сард 1 удаа өгсөн 82800 хүн/ цаг Аваар осолгүй ажилласан.	ХАБЭА-н дүрэм журам
3	Уурхайн хотхон, тоног төхөөрөмжид гал гарах. Аянга, цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул учрах	Галын хор, гал унтраах багаж хэрэгсэлийг уурхайн кемп, ШТС, засварын хэсэг, техник тоног төхөөрөмжүүдэд байрлуулан тэмдэг тэмдэглэгээг тавьсан. Уурхайн ажлын талбар, технологийн зам, засварын хэсэг, үйлдвэрийн болон хаягдлын сан зэрэг аюултай хэсэгт анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулан ажилласан.	“Галын аюулгүй байдлын тухай” хууль
4	Устай борооны улмаас ордын олборлолт явуулж буй талбайд ихээхэн хэмжээний ус цутган орсноос ослын байдал гарч болно.	Үер усны аюулаас сэргийлж ил уурхайн хүрээ ирмэг, ээр хамгаалалтын шороон далан хийсэн. Шимт хөрсөөр хучсан талбай үерийн усаар урсах эрсдэлтэй байсан тул тойруулан ус тогтоох зориулалтай хамар хийсэн. Хайлаастай жалгын дагуу үерийн ус зайлуулах суваг татаж, сувгийг хүчтгэж том чулуунгаар хаалт хийсэн	“Гамшигаас хамгаалах тухай” хууль

ЕС. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, үлдсэн хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор устгах зарчмыг баримтлан хог хаягдлыг зүй зохистой удирдан зохицуулахыг зорьж ажилладаг.

Ажилчдын байр, хоолны газар, амрах өрөө, засвар үйлчилгээний хэсэг, агуулах зэрэг объектуудад байрнуудаас хатуу шингэн хог хаягдал гардаг. Эх үүсвэрээс гарч буй хог хаягдлыг дахивар болон идэвхигүй хаягдал, аюултай болон аюулгүй зэргээр ангилдаг.

Шингэн хог хаягдал: Ахуйн бохир ус, ашигласан тос, түлш шатахууны хаягдал.

Хийн хаягдал: “ГБНБ” ХХК-ний уурхайд ажилчдыг байрыг тосон тен ашиглаж халаадаг, Гал тогоонд хийн тогоо ажиллуулдаг тул хийн хортой хаягдал үүсдэггүй.

Ахуйн хог хаягдал: Ажилчдын амрах байр тус бүр дээр галын хор болон хогийн сав байрлуулсан.



- Долоо хоног бүрийн ням гаригт уурхайн кемпд их цэвэрлэгээ хийж, хог хаягдлыг ангилан түр хогийн цэгт асгуулж байсан.



- Уурхайн хотхоны хогийн цэгийг тойруулан хамгаалалтын хашлага татсан. Уурхайн хогийн цэгт хуримтлагдсан хог орчныг бохирдуулах, өвчин үүсгэгч нян, бактер өсөж үржихээс сэргийлэн хлорын уусмалаар сар бүр ариутгал хийдэг. Хоол хүнсний хаягдлыг нохойд өгч усгадаг.



- Аюултай хог хаягдлыг цуглуулах, тусгай сав байрлуулсан.



- Дахин ашиглагдах хуванцар, ундааны сав хаях цэг байглууж ангилан ялгаж байна



Хатуу хог хаягдал: Үйлдвэрийн хэсэг, угаах төхөөрөмж, техникүүдийн эд ангийн эвдрэлээс үүдэж төмрийн хог хаягдал бий болдог.



Зураг. Хуучин акумлятор, автомашины дугуйн хаягдал.

- Хаягдал дугуй, акумлятор, шүүр, хаягдал төмрийг засварын талбайн хажууд байрлах талбайд хурааж, “Гацуурт” ХХК-д нийлүүлдэг.

Ус татах шугам хоолойг наах үед гарсан хог хаягдлыг цэвэрлүүлж шатаах зууханд хийж устгадаг.



Зураг. Хуванцар хаягдал

Шингэн хаягдал: Уурхайн техникүүдэд 250, 500, 1000 мото.цагийн тос масло солих үйлчилгээ дагуу хийгддэг тул хаягдал тос масло гардаг. Техникийн засвар үйлчилгээг тусгай цементэлсэн талбайд хийж хаягдал тос маслаг тусгай саванд хийж хураадаг.

Энэ онд 2700 литр хаягдал тос маслаг Гацуурт ХХК-нд нийлүүлсэн.



Хүснэгт. Хог хаягдлын хэмжээ, авсан арга хэмжээ

	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын төрөл	код	Гарсан хог хаягдлын хэмжээ <i>Шингэн-(м³/жил)</i> <i>Хатуу-(тн/жил)</i>	Дахин ашиглах	Устгах	Хадгалах	Ландфилл	Тээвэрлэгчид нийлүүлэх
Ахуйн	Цаас, картон	A 01 01	300 кг	+	+	+		
	Шил	A 01 02	5 кг			+		+
	Биозардалд ордог хоол хүнсний бүтээгдэхүүний хаягдал	A 01 03	380 кг	+			+	
	Бохир ус, хаягдал	A 01 05	-		+		+	
	Сав, баглаа, подон		30 ш	+	+	+		
Үйлдвэрийн	Тос, масло	T 05 01	2.7 тн	+		+		+
	ШТМ-н		0.2 тн	+		+		
	Дугуй	T 02 00	21 ш			+		+
	Акумлятор		38 ш			+		+
	Тосны шүүр	A 01 04	265 ш			+		+
	Агаар шүүгч		120 ш			+		+
	Төмөр	A 01 14	40 тн			+		40 тн
	Арчих материал		50 кг	+	+			
Хуванцар		3 шуудай	+		+			
Аюултай хортой	Эм тариа, сав боглоо, нүүрний маск, хэрэгсэл		-		+	+		
	Хуруу зай,		8 ш		+	+		

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт .

№	Хог хаягдлын ангилал	Хог хаягдлын төлөвлөгөө	Хамрах хүрээ	Авсан арга хэмжээ, гүйцэтгэл	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлын талаар сургалт хийх	Төслөөс гарах хог хаягдал	Хогийн савыг объект тус бүрд байрлуулж. хог хаягдлыг ангилан ялгах зөвлөмж, сургалтыг ажилчдад сар бүр хийсэн.	Хог хаягдлын тухай хуулийн 9-р зүйл
2		Уурхайн тосгон, засварын талбайд цэвэрлэгээ хийх	Төслийн талбай	Уурхайн кемпийг долоо хоногт нэг удаа, Засварын талбайг сардаа нэг удаа их цэвэрлэгээ хийлгэдэг.	Хог хаягдлын тухай хууль
3		Ахуйн хогийн цэгийг ариутгах	Хогийн цэг	Ахуйн хогийн цэгийг сард нэг удаа хлорын уусмалаар ариутгасан.	
4	Үйлдвэрийн	Хаягдал тос масло, төмөр, аккумулятор, дугуй зэргийн зориулалтын талбайд цуглуулах, гэрээт компанид нийлүүлэх	Засварын талбайд	40 тн хаягдал төмөр, 38 ш хаягдал аккумулятор, 2700 л хаягдал тос масло-г Гацуурт ХХК-д нийлүүлсэн.	Хог хаягдлын тухай хууль
5		Хаягдлын цэгийг эмх цэгцтэй болгох	Засварын талбай	Ахуйн хогийн цэгийг тойруулан татсан торыг сэргээн зассан. Засварын талбайн хаягдлын цэгийг сар бүр цэвэрлэж цэгцэлдэг.	
6		Орон нутагтай хог хаягдлын гэрээ хийж, хамтран ажиллах	Уурхайн хэмжээнд	Бүрэгхангай сумтай энгийн хог хаягдлын гэрээг 2023 оны 8 сард байгуулсан. Хог хаягдлын 3.5 сая.төг төлбөрийг төлсөн Уурхайд 30 хүн ажиллаж байгаа ба энэ жил орон нутгийн төвлөрсөн хогийн цэгт хог хаягдал хаяагүй.	Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
7	Аюултай	Аюултай хог хаях, цуглуулах сав байрлуулах. Анхааруулах тэмдэглэгээ хийх, устгах	Уурхайд	Аюултай хог хаях, цуглуулах сав байрлуулан, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ хийсэн.	Хог хаягдлын тухай хууль

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Тухайн төслийг хэрэгжүүлсэнээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулахын тулд 5 болон 7 дугаар сарууд 2 удаагийн давтамжтайгаар уурхайн хяналтын цэгүүдээс хөрс, ус, агаарын дээж авч шинжилгээ хийлгүүлсэн.

Хөрс ус агаарын шинжилгээ:

- ✓ 5 дугаар сард - Булган аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газрын харьяа байгаль орчны шинжилгээний лаборатороор хөрс, ус, агаарын нийт 8 хэсэгт дээж авхуулж шинжлүүлсэн.
- ✓ 7 дугаар сард – БОАЖЯ-ны харьяа байгаль орчны судалгаа шинжилгээний төв лаборатороор хөрс, усны нийт 18 хэсэгт дээж авч шинжлүүлсэн.

Уурхайн бүсэд 5, 8 саруудад хийлгэсэн шинжлүүлсэн шинжилгээгээр давсан үзүүлэлт гараагүй. Орчны хяналт шинжилгээний үр дүнг тайланд хавсаргав.



Зураг: Хөрс, ус дээж авч буй байдал

Жич: Шинжилгээний сорилтын дүнг хавсаргав.

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

	Төлөвлөгөө			Биелэлт			
	ОХШ-ний төрөл, арга, хэлбэр	Байршил	Давтамж	ОХШ-н хийсэн цэгийн байрлал	Давтамж	Шинжилгээний дүн	Аргачлал.
1. Агаарын чанар	Агаарын шинжилгээг (NO ₂ мг/м ³ , SO ₂ мг/м ³ , CO мг/м ³ , Тоос мг/м ³ , Цацраг мг/м ³ зэрэг MNS4585:2016 стандартын аргачлалаар хийлгэсэн.	1. Ил уурхай 2. Уурхайн кемп	5, 7 сард	Ил уурхайд	1	хэвийн	MNS 4585:2016
				Уурхайн кемп	1	хэвийн	
2. Хөрсний чанар	Чийг %, рН, (NH ₄ , NO ₃ , SO ₄ , P ₂ O ₅ , Pb, Cu, Cd, Нефьт мг/кг Зэргийг MNS 5850:2008 стандартын дагуу авах	1. Шимт хөрсний овоолго 2. Уурхайн кемп 3. Засварын талбай 4. Хог хаягдал цэг 5. ШТМ-ын агуулах 6. Нүхэн жорлон 7. Төмрийн хаягдал 8. Угаах төхөөрөмж	5, 7 сард	Шимт хөрс	2	хэвийн	MNS 3310:91
				Уурхайн кемп	2		
				Завсарын талбай	2	хэвийн	MNS ISO 11047:2001
				Хогийн цэг	2	хэвийн	MNS 6838:2020
				Нүхэн жорлон	3	хэвийн	MNS 5850:2019
				Ахуйн бохирдол	1	хэвийн	
				ШТС	1	хэвийн	
				Төмрийн хаягдал	1	хэвийн	
				Угаах төхөөрөмж	1	хэвийн	
3. Усны чанар	Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (Ca CO ₃), Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрсустөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)	- Ундны усны эх үүсвэр, - Тунаах нуур - Уурхайн карьер шүүрлийн ус - Туул гол насосны орчим	5, 7 сард	Гүний худаг	2	хэвийн	MNS 0900:2018
				Тунаах нуур	2	хэвийн	MNS 4586:1998
				Туул гол /насосны суурь/	1	хэвийн	MNS 4585:98 MNS 4586:98
				Шүүрлийн ус /карьерт/	1	хэвийн	MNS 4943:2015 MNS 4586:1998 MNS ISO 11885:2011
Нийт зардал		сая.төг		сая.төг	16		

АРВАННЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

”ГБНБ”ХХК ерөнхий захирлын тушаалаар уурхайн дарга Н.Болд, Маркшейдер А.Баасан, Уулын мастер Игорьиванович гончарук нараар ахлуулсан уурхайн нөхөн сэргээлтийн хэсэг ажилладаг. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө болон байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх бүхэл сөрөг нөлөөллийн хамгийн бага байлгах аргаар тооцож байгаль орчны бодлого зорилгод нийцсэн арга хэмжээнүүдийг авч ажилласан.

Бид уул уурхайн компаний байгаль орчны бодлого, менежментийн системийг доорх маягаар тодорхойлж ажилладаг.

Уурхайн байгаль орчны бодлого:

- Үйл ажиллагааныхаа бүх үе шатанд байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, дараахь эрхэм зорилгыг баримтлан ажиллана.
- Монгол улсын холбогдох хууль тогтоомжууд болон олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөнө.
- Байгаль орныг хамгаалах ажлын гүйцэтгэлийг байнга сайжруулах.
- Нутгийн ард иргэдийн уламжлалт соёл, өв уламжлалыг хүндэтгэж хамгаалах.
- Байгаль орчинд халгүй, үйл ажиллагааны үр ашгийг тогтмол дээшлүүлэх шинэ дэвшилтэт технологийг хөгжүүлэх, нэвтрүүлхийг эрмэлзэнэ.

БОМТ-ний биелэлтийг удирдлагын хүрээнд авч үзэж, биелэлтэд нь тогтмол хяналт тавьж ажиллах шаардлагатайн зэрэгцээ энэ асуудлаар байгаль орчны хяналтын байгууллагатай холбоотой ажилдаг. Тусгагдсан ажлуудыг жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж хэрэгжүүлдэг билээ.

Удирдлага зохион байгуулалтын хэмжээнд хийгдэх ажлын төлөвлөгөөний биелэлт

Д.д	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хариуцагч	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал сая.төг	Баримтлах хууль, журам
1.	Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах	Захирал	2012 оны А-12 тоот захирлын тушаалаар Уурхайн дарга Н.Болд, Маркшейдер А.Баасан нарыг Баруун захцагийн уурхайн байгаль орчны асуудлыг хариуцан ажилуулахаар томилсон.	-	“Байгаль хамгаалах тухай” хууль
2.	БОНБУ болон БОХТ, ОХШХ-г заасан сөрөг нөлөөлөлийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх	Уурхайн дарга	ОХШ-г Булган аймгийн УЦУОШГ-ын БОШЛаборатор болон БОАЖЯ-ны БОсудалгаа шинжилгээний лаборатороор тус тус хийлгэсэн. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж хэрэгжүүлэн ажиллаж байна.	ОХШХ-г	
3.	Ажилчдад ХАБЭА-н сургалт, байгаль орчныг хамгаалах сургалт зохион байгуулж хамруулах	ХАБЭА-н ажилтан	ХАБЭА-н сургалтыг 4-р сард мэргэжлийн байгуулагаар хийлгэсэн. Уурхайн ажилчдад өдөр тутмын ажлын байрны АА-ны болон давтан зааварчилгааг өдөр бүр өгч зааварчилж ажилласан.		
4.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах	Уурхайн дарга, Маркшейдер	БОМТөлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг БО-ны газар блон орон нутгийн удирдлагат тайлагнаж байна. Хаалтын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан УУЯ-БОАЖЯ-д хянуулахаар хүргүүлсэн	-	
5	Нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж орон нутагт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах	Уурхайн дарга, Маркшейдер	Техникийн нөхөн сэргээлт 8.7 га төлөвлөсний 11.5 га, Биологийн нөхөн сэргээлт-5.3 га, 6.2 га-д хийж ажлын хэсэгт өгч байна.	-	
6.	Хог хаягдал, Газрын болон ус ашигласны төлбөр, бохирдуулсаны төлбөр бусад татвар хураамжыг төрийн санд төвлөрүүлэх.	Уурхайн дарга, Маркшейдер	Газрын төлбөр -38.0 сая.төг Ус бохирдуулсан -12.9 сая.төг Ус ашигласны -78.285 сая.төг төлбөрийг	-	
	Нийт зардал /сая.төг/				

**АРВАНХОЁР. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД
ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Булган аймгийн Бүрэгхангай сумын Дэрст багийн иргэдийн нийтийн хуралд 2023 оны 10 дугаар сарын 31 оролцож Баруун захцагийн шороон орд”-ын 2023 оны БОМТөлөвлөгөөний биелэлтийн тайлан, Нийгмийн хариуцлагийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, хаалтын төлөвлөгөөнд санал авсан байгаа.

Уурхайд шалгалтаар ирсэн орон нутгийн болон төрийн байгууллагуудын ажлын хэсэгт уурхайн үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн ажлыг танилцуулсан. Бид төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг холбогдох журмын дагуу БОАЖЯам, Булган аймгийн БОАЖГ, Бүрэгхангай сумын удирдлагуудад хүргүүлсэн.



Зураг. Бүрэгхангай сумын Дэрст багийн иргэдийн нийтийн хуралд оролцсон.

2023 оны БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөлтийн биелэлт

№	Оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах газар	Хугацаа
1	Бүрэгхангай сумын 3-р багийн ИНХ-д оролцох	Хуралд танилцуулах	Ш-р багийн Иргэдийн нийтийн хуралд оролцож БОМТ-ийн биелэлт, Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлыг танилцуулав.	3-р Багийн төв	2023.10.31
2	МХЕГ, Булган аймгийн БОАЖГ, МХГ, Татварын байцаагч	Уулзалт, тайлагнах	Уурхайн үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн ажлын явц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Нийгмийн хариуцлагын хүрээний ажил	Төслийн талбайд	2023 онд
3	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т албан бичиг	БОМТ, БОМТ-ний биелэлтийн тайланг хүргүүлэх	БОМТ-ний биелэлтийн тайлан, БОМТөлөвлөгөөг цахимаар хянуулж баталгаажуулсан.	Улаанбаатар хот	12 сард

ДҮГНЭЛТ

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа 2019 оны 10 сарын 29 –ний өдрийн БОАЖЯ-ийн сайдын А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болгов. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгахыг зорьж ажилласан.

БОМТ-ний гүйцэтгэлийн зардал.

Хүснэгт.

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	Төсөв /сая.т/	Тайлбар
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах	2.8	
2.	Нөхөн сэргээлт		
	Техник	63.73	
	Биологи	5.78	
3.	Дүйцүүлэн хамгаалах ажил	16.3	
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	-	
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах	-	
6.	Осол эрсдлийн менежмент	ХАБЭА-н зардалд тусгав	
7.	Хог, хаягдлын менежмент	3.5	
8.	Химийн бодисын эрсдэлийн менежментийн тайлан	-	
9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4.4	
10.	Удирдлага зохион байгуулалт	Үйл ажиллагааны зардалд тусгав	
11.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах	Үйл ажиллагааны зардалд тусгав	
	Нийт зардал	96.51	